

Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх



Залбирахыг ТЭДЭНД УХУУЛ

Бяцхан хүүхэд байхад маань эцэг эх минь надад хэрхэн залбирахыг зааж өгсөн юм. Би залбирч эхлэхдээ Тэнгэрлэг Эцэгийг алс хол байгаагаар төсөөлөн боддог байлаа. Нас минь нэмэгдэх тусам залбирах үйл явц маань өөрчлөгдсөн. Би Тэнгэрлэг Эцэгийг хурц гэрлээр хүрээлэгдсэн, надад их ойрхон байдаг, намайг сайн мэддэг хэмээн төсөөлдөг болсон юм.

1820 онд Нью-Йоркийн Манчестерт Иосеф Смитэд тохиолдсон үйл явдлын тухай түүний бичсэн зүйлийг үнэн гэдэг гүн гэрчлэлтэй болсон тул Тэнгэрлэг Эцэгийн тухай төсөөлөл маань ийн өөрчлөгдсөн билээ.

“Өөрийнхөө чанх орой дээр нарнаас илүү хурц гэрэлтэй гэрлэн багана над уруу алгуурхан доош бууж ирэхийг би харлаа.

Намайг хүлсэн тэрхүү дайснаас миний бие чөлөөлөгдсөн нь удалгүй мэдэгдэв. Мөнөөх гэрэл над дээр тогтоход гялалзсан өнгө хийгээд алдар суут нь дүрслэхийн аргагүй хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би харав. Тэдний нэг нь намайг нэрээр минь дуудан, нөгөө рүүгээ заагаад надад—“Энэ бол Миний Хайртай Хүү. Түүний үгийг сонсогтун! хэмээв.” (Иосеф Смит—Түүх 1:16–17).

Хаврын тэр нэгэн сайхан өдөр Тэнгэрлэг Эцэг ойн

цоорхойд байсан бөгөөд Иосефийг нэрээр нь дуудсан билээ. Тэгээд Тэрээр дахин амилсан дэлхийн Аврагчийг Өөрийн “Хайрт Хүү” хэмээн танилцуулсан юм. Та хэзээ ч, хаана ч залбирсан тэрхүү агуу үйл явдлын тухай гэрчлэл тань таныг адисалж чадна.

Бидний хандан залбирдаг Эцэг маань Өөрийн Хайрт Хүүгээрээ дамжуулан дэлхийнүүдийг бүтээсэн гайхамшигт Бурхан юм. Тэрээр Иосефийн залбирлыг сонссоны адил Түүний оршихуйд байгаа мэтээр бидний залбирлыг сонсдог. Тэрээр бидэнд маш их хайртай учир Өөрийн Хүүг бидний Аврагчаар илгээсэн. Бурхан бидэнд тэрхүү бэлгээр дамжуулж үхэшгүй мөнхийн амьдралыг авах боломжийг өгсөн. Энэ амьдралдаа хүссэн үедээ Есүсийн Христийн нэр дээр залбиран, Түүнтэй харилцах боломжийг Тэр бидэнд санал болгосон.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн санваар атгагчид “гишүүн бүрийн гэрээр айлчлан *чанга дуугаар болон чимээгүй залбирахыг ухуулах*” (С ба Г 20:47) үүрэгтэй.

Залбирахыг ухуулах олон арга зам байдаг. Жишээлбэл үргэлж залбирч байх Бурханы тушаалын тухай бид гэрчилж болно. Эсвэл талархаж, гуйж хүсч, асууж лавлан залбирсан тухай судрын жишээнүүдээс мөн өөрсдийн туршлагаасаа хуваалцаж болно.

Жишээ нь би Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд хариулдаг гэдгийг мэднэ хэмээн гэрчилж чадна. Оюун ухаандаа хүлээн авсан үгсээс ирэх удирдамж болон тайтгаралаасаа би эдгээр үг нь Бурханаас ирсэн гэдгийг Ариун Сүнсээр дамжуулан мэддэг.

Бошиглогч Иосеф Смитэд ийм явдлууд тохиолдсон бөгөөд танд ч мөн тохиолдох боломжтой. Чин сэтгэлийн залбирлынхаа хариуд тэр:

“Хүү минь, сүнсэнд чинь амар амгалан байг; саад тогтор хийгээд зовлон зүдгүүрүүд чинь хэсэг хугацаанд байх болно;

Мөн тэгээд, хэрэв чи үүнийг дажгүй давбал, Бурхан чамайг тэнгэрт өргөмжлөх болно” (С ба Г 121:7–8) гэсэн хариултыг авсан билээ.

Энэ бол маш ихээр зовж шаналж байсан итгэлтэй хүүдээ өгсөн Хайрт Эцэгийнх нь илчлэлт байлаа. Бурханы хүүхэд бүр залбирлаар дамжуулж Түүнтэй харилцаж чадна. Түүнд даруухнаар залбиран хайр болон гэрэлт мэдрэмжүүдийг хүлээн авах нь надад залбирах урам зоригийг юу юунаас илүүтэйгээр өгдөг юм.

Бид Бурханы тушаалуудыг дагаснаар тушаалуудын тухай гэрчлэлтэй болдог (Иохан 7:17-г үз). Чангаар болон чимээгүйхэн тогтмол залбирах тушаал нь үнэн тушаал юм. Бурхан та нарын залбирлуудад хариулдаг бөгөөд Ариун Сүнсний хүчээр хүлээн авдаг хариулт бүр Түүнээс ирдэг гэдгийг та бүхэн мэдэж чадна гэдгийг би та бүгдийн найз мөн багшийн хувьд амлаж байна.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

- “Зургууд нь хичээлийн гол санааг хүчирхэгжүүлэхэд чухал үүрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 176). Иосеф Смит эсвэл Анхны үзэгдэл зургийг үзүүл. Иосеф Смитийн залбирлын тухай ярилц. Залбирахдаа

Ерөнхийлөгч Айрингтай адил “Тэнгэрлэг Эцэгийг ойрхон байгаа” мэтээр төсөөлөх нь яагаад чухал вэ?

- Ерөнхийлөгч Айрингын зөвлөснөөр залбирч, залбирлын тухай судруудаас хуваалцсанаар хүлээн авсан адислалуудынхаа тухай гэрчлэлээ хуваалцаж болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Миний итгэлийн залбирал

Присила Фариас д.Лима

18 настай байхдаа би нэгэн тавилгын дэлгүүрт худалдагчаар ажилладаг байлаа. Миний ажлын цагийн хуваарь маш урт байв. Би даваа гарагаас бямба гараг хүртэл өглөө 8-аас орой 10 цаг хүртэл ажилладаг байсан. Сүмийн үйл ажиллагаануудад оролцож, институтэд явж чаддаггүй байсан болохоор надад гунигтай байлаа.

Ингээд би институт болон үйл ажиллагаануудад оролцохын тулд бямба гарагт ажилладаггүй ажил олж өгөхийг гуйж Тэнгэрлэг Эцэгтээ хандан маш итгэлтэйгээр залбирч эхэлсэн юм.

Нэг өдөр би нэгэн худалдан авагчид тусалж байлаа. Бид ярилцаж эхэлсэн бөгөөд тэр өөрийгөө банкинд ажилладаг гэж хэллээ. Би түүнээс банкны салбарт ажиллахын тулд юу хийх ёстойгоо асуулаа. Тэрээр надад өөрийн нэр, утасныхаа дугаарыг өгч, ажилд авдаг хүн рүү утасдан намайг таньдаг гэж хэлээрэй гэв. Би банк руу очиж өгөх хэрэгтэй шалгалтыг нь өглөө. Би тэр шалгалтыг давсан бөгөөд даваа гарагаас баасан гараг хүртэл өдөрт зургаан цаг ажилладаг боллоо. Мөн урьд авч байсан цалингаасаа 3 дахин их мөнгө авдаг болсон.

Их Эзэнийг нэгдүгээрт тавих хүсэлтэй байвал Тэр биднийг удирдан чиглүүлдэг гэдгийг би мэднэ. Тэр намайг өнөөдөр ч удирдан чиглүүлж байна. Залбирлын зарчим үнэн гэдгийг би мэднэ.



Итгэл, Гэр бүл, Халамж

Гэр бүл, гэр орноо сахин хамгаалагчид

Энэ материалыг судалж, гэрээр нь очиж заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар ярилц. Эгч нарыг хүчирхэгжүүлж, Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли 1995 онд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий чуулган дээр ‘Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг’-г танилцуулахдаа “Та нар бол гэр бүл, гэр орноо сахин хамгаалагчид” хэмээн хэлсэн юм. “Та нар хүүхдүүд төрүүлэн, тэднийгээ өсгөн хүмүүжүүлж, зан аашийг нь төлөвшүүлдэг билээ. Бурханы охид, хөвгүүдийг өсгөн хүмүүжүүлэх нь хамгийн тэнгэрлэг ажил мөн.”¹

Бараг 17 жилийн турш энэ тунхаг нөхцөл байдал ямар ч байсан гэр бүлээ хүчирхэгжүүлэх нь бидний хамгийн чухал үүрэг хариуцлага мөн гэж баталдаг. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөхөөр үйлчилж байгаа Барбара Томпсон эгч Солт Лейк Табернакльд Ерөнхийлөгч Хинклиг тэр тунхагийг анх удаа уншихад тэнд байжээ. “Тэр бол онцгой сайхан үйл явдал байсан” хэмээн тэр дурсжээ. “Би тэр захиасыг маш чухал болохыг мэдэрсэн. ‘Энэ бол эцэг эхчүүдэд сайн удирдамж, мөн тэдэнд өндөр үүрэг хариуцлагыг ноогдуулж байна’ гэж би бодож билээ. Би гэрлээгүй бас хүүхэдгүй тул надад ч нэг их хамаагүй юм байна хэмээх бодол толгойд оров. Тэгээд тэр даруй ‘Үгүй ээ энэ надад ч бас хамаатай

юм байна. Би бол энэ гэр бүлийн гишүүн. Би бол хэн нэгний охин, эгч, дүү, авга эгч, нагац эгч, зээ охин, ач охин нь мөн. Гэр бүлийн гишүүний хувьд надад ч гэсэн үүрэг хариуцлага, адислалууд байдаг. Би гэр бүлээсээ цор ганцаараа үлдсэн байлаа ч Бурханы гэр бүлийн гишүүн хэвээр бөгөөд бусад гэр бүлийнхнийг хүчирхэгжүүлэх үүрэг хариуцлага надад байдаг.’”

“Аз болоход энэ хүчин чармайлтыг гаргахад бид ганцаараа биш. Гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэхэд Христийн сургаалийг сурч, үүнийг дагаж мөн Түүний тусламжинд найдах нь хамгийн агуу тусламж болдог” гэж Томпсон эгч хэлсэн.”²

Бидний түүхээс

Батшеба В.Смит эгч [1901 оноос 1910] оны хооронд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгчөөр үйлчилж байх үедээ гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх хэрэгтэй байгааг анзаарч, Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нарт зориулж эхчүүдийн боловсрол хичээлүүдийг үүсгэн бий болгожээ. Эдгээр хичээл нь гэрлэлтийн талаар зөвлөгөө өгч, жирэмсэн эхчүүдийн арчилгаа болон хүүхэд өсгөх талаар заадаг. Эдгээр хичээл нь гэр оронд эмэгтэйчүүд ямар үүрэг хариуцлагатай болох тухай Ерөнхийлөгч Иосеф Ф.Смитийн

заасан зүйлсийг дэмждэг юм.

“Гэр бүлд гэр бүлийн үүрэг хариуцлагын талаар эхнэр, нөхөр түүнчлэн эцэг эх, хүүхдүүдийн хооронд үл тоомсорлох эсвэл үл ойлголцох явдал үүсэх үед гэр бүлийн чухал үүрэг хариуцлагуудад бэлтгэж ”³

Эшлэл

1. Гордон Б.Хинкли, “Stand Strong against the Wiles of the World,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 101.
2. Барбара Томсон, “I Will Strengthen Thee; I Will Help Thee,” *Лиакхона, Ensign*, 2007 оны 11-р сар, 117.
3. *Миний Хаант Улсын охидууд: Нийгмийн Халамжийн Бүлгийн түүх ба ажил* (2011), 153

Судруудаас

Сургаалт үгс 22:6; 1Нифай 1:1; 2 Нифай 25:26; Алма 56:46–48; Сургаал ба Гэрээ 93:40

Би юу хийж чадах вэ?

1. Өөрийн хариуцдаг эгч нартаа гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд нь би хэрхэн туслах вэ?
2. Би гэр бүлийнхэндээ хэрхэн зөв нөлөө үзүүлж чадах вэ?

Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org вэб хуудсаас үзнэ үү.